



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 375

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтооюор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дэх заалт, Сангийн сайдын 2019 оны “Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны давсан орлогыг зарцуулах тухай” 185 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагагаа лабораторийн 2019 оны үйл ажиллагааны давсан орлогоос албан хэрэгцээнд зориулан 40,000,000.00 (дөчин сая) төгрөгт багтаан автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.
2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагагаа лабораторийн ерөнхий захирал Б.Амар нарт дор дүрдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:
 - 2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;
 - 2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
 - 2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан мэдээ, тайлангийн баталсан маягаар ирүүлэх.
3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР



Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны 09 дугаар сарын 19-ний
өдрийн 31 дугаар тогтоогын хавсралт

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН ХУДАЛДАН АВАХ
АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮННИЙ ДЭЭД ХЯЗГААР

№	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1	Сүүдлын тоо 12, хөдөлгүүрийн багтаамж 2500- 3000сс /улсын дугаар аваагүй/	ш	1	40,000,000.00
	Нийт дүн		1	40,000,000.00 (дөчин сая төгрөг)